

# БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Баянхонгор аймгийн худалдаа, зочид буудал,  
зоогийн газрын салбарын 2019 оны танилцуулга

Баянхонгор хот

2020 он

## НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо гэж тайлант хугацаанд статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй тухайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоог ойлгоно.

Статистикийн бизнес регистр гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг агуулсан мэдээллийн сан юм.

Нэмэгдэл өртөг гэж нийт үйлдвэрлэлтээс завсрын хэрэглээг хассан дүнг хэлнэ.

Нийт үйлдвэрлэлийг үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ.

Завсрын хэрэглээ гэж үйлдвэрлэл, үйлчилгээний явцад орц болж зарцуулагдсан бүтээгдэхүүний зардал (худалдан авсан барааны өртгөөс жилийн эцсийн нөөцийн өөрчлөлтийг хасна) болон үйлчилгээний төлбөрийг хэлнэ.

Нийт үйлдвэрлэл ААНБ-уудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас олсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчиддаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаанаас орсон орлогын дүнг хэлнэ.

Нийт борлуулалт гэж тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалтын дүн бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгжийн “цэвэр борлуулалт”-ын нийлбэрээр тооцно.

Хөдөлмөрийн бүтээмж гэж нэмэгдэл өртгийг бий болгоход хөдөлмөрийг хэрхэн үр бүтээлтэй ашиглаж байгааг харуулна.

Зочид буудал гэж хот, суурин газарт байрласан, зочид үйлчлүүлэгчдийг хүлээн авч байр, хоолны болон бусад үйлчилгээ үзүүлдэг цогцолборыг хамруулна.

## ОРШИЛ

Сүүлийн жилүүдэд бизнесийн жишигт нийцсэн худалдаа үйлчилгээний төвүүд олноор бий болж байна.

Эдгээрээс аймгийн худалдааны салбар нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30.2 хувь, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 13.1 хувийг бүрдүүлж, аймгийн эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг салбарын нэг юм. Түүнчлэн, аймгийн худалдааны салбар нь аймгийн хөдөлмөрийн зах зээлд онцгой үүрэг гүйцэтгэдэг салбаруудын нэг бөгөөд 2019 оны байдлаар аймгийн тус салбарт 3.7 мянган хүн ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд эрүүл ахуйн шаардлага хангасан бизнесийн жишигт нийцсэн худалдаа үйлчилгээний төвүүд олноор баригдах болсон нь бизнесийн таатай орчин бүрдүүлэх бодлогоор уг салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжсэнтэй холбоотой юм.

Энэхүү танилцуулгад худалдаа, зочид буудал, зоогийн газрын салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо, ажиллагчдын тоо, нийт борлуулалт, нэмэгдэл өртөг, хөдөлмөрийн бүтээмж зэрэг мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Аймгийн худалдаа, зочид буудал, зоогийн газрын салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болох юм.

**ХУДАЛДААНЫ САЛБАР – 2019**

**Баянхонгор хот  
2020 он**

## **Салбарын онцлог**

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж нь өөрөө үйлдвэрлэл явуулахгүй боловч үйлдвэрлэгчээс бараа, материал худалдан авч, ямар нэг нэмэлт боловсруулалт хийлгүйгээр дахин худалддаг онцлогтой салбар бол худалдааны салбар юм. Худалдааны байгууллагууд ихэнхдээ бөөний болон жижиглэн худалдаа дагнах эсвэл холимог хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна.

Бөөний худалдаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эсвэл дараагийн шатны худалдаанд зориулан бөөнөөр борлуулах үйл ажиллагааг хамруулдаг бол харин жижиглэн худалдаанд хүн амын хэрэгцээнд зориулсан өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд дахин боловсруулалт хийлгүй эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа багтдаг.

## **Хамрах хүрээ**

Дотоод худалдааны салбар нь “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” 4.0-ын дагуу дараах 3 дэд салбараас бүрддэг.

Үүнд:- Машин, мотоцикл, түлш, шатахууны худалдаа, засвар үйлчилгээ дэд салбарт шинэ болон хуучин автомашин мотоциклийн бөөний болон жижиглэнгийн худалдаа, техникийн засвар үйлчилгээ, сэлбэг шатахууны жижиглэн худалдаа (код 45),

- Машин, мотоциклоос бусад барааны бөөний болон комиссын худалдаа дэд салбарт жижиглэн худалдаа, үйлдвэр, байгууллагын хэрэгцээнд барааг бөөнөөр нийлүүлдэг байгууллага, экспорт, импорт эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа (код 46),

- Машин, мотоциклоос бусад барааны жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээ дэд салбарт хүн ам, гэр ахуйн хэрэгцээнд зориулан дэлгүүр, лангуу, үүргийн болон захиалга, дуудлагаар бараа худалдах үйл ажиллагаа (код 47) зэрэг багтана.

Дотоод худалдааны салбарын хамрах хүрээг албан болон албан бус гэж 2 хуваан авч үзэж ДНБ-ий тооцоонд тусгаж байна.

Албан секторын хамрах хүрээ нь бизнес регистрийн санд бүртгэлтэй бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт болно.

Албан бус секторын үйл ажиллагаанд албан ёсоор аж ахуйн нэгж, байгууллага гэж бүртгэгдээгүй, патентын зөвшөөрөлтэй хувиараа худалдаа эрхлэгчдийг оруулж байна. Эдгээрт лангуу, чингэлгийн худалдаа, түргэн үйлчилгээний цэгүүд, гутал засвар, авто засварын үйл ажиллагаанууд орно. I

### ААНБ-ын тоо

Бизнес регистрийн санд бүртгэлтэй худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 183 ААНБ байгаа нь нийт аж ахуйн нэгж, байгууллагын 13,1 хувийг эзэлж байна.

#### Худалдааны салбарын үйл ажиллагаа явуулж байгаа ААН, Байгууллагын тоо

Үзүүлэлт	2018	2019
Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо аймгийн дүнгээр/	1262	1394
Үүнээс:Худалдааны салбарын ААНБ-ын тоо	152	183
Худалдааны салбарын ААНБ-ын эзлэх хувь	12.0	13.1

2019 оны байдлаар худалдааны салбарт 3701 хүн ажиллаж байгаа бөгөөд аймгийн нийт ажиллагчдын 11,1 хувийг эзэлж байна.

#### Худалдааны салбарын ажиллагчдын тоо

Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Аймгийн нийт ажиллагчдын тоо	40009	40921	41458	33384
Худалдааны салбарын ажиллагчдын тоо	3095	4428	4675	3701
Аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь	7.7	10.8	11.3	11.1

2019 онд худалдаа үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30,2 хувийг эзэлж байна.

#### АЙМГИЙН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	2016	2017	2018	2019
Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр сая,төгрөг/	353493,0	399785,0	417659.1	476761.7
Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний дүнд эзлэх хувь	100	100	100	100
Хөдөө аж ахуй	45,1	43,9	44.3	43.5
Аж үйлдвэр, барилга	23,7	26,0	25.9	26.3
Үйлчилгээ	31,2	30,1	29.9	30.2

2019 онд худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгж байгууллагуудаас 62 ААН-ийг түүврээр сонгон ҮСХорооноос ирүүлсний дагуу статистик мэдээнд улирал тутам хамруулсан.

Дээрх сонгогдон ирсэн Аж ахуйн нэгжийн 2019 оны нийт борлуулалтын орлого 54,6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оныхоос 3,0 хувиар өсчээ.

### ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2019/2018
Нийт борлуулалт /аймгийн дүнгээр, сая төгрөг/	25221,3	31291.0	53078.4	54674.3	103.0



Аймгийн худалдааны нийт борлуулалт улсын худалдааны нийт борлуулалтын 0,23 хувийг эзэлж байна.

### ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, улс, аймгийн дүнгээр, сая төгрөгөөр

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Нийт борлуулалт /улсын дүнгээр/	13170891.3	15697003.3	20958538.4	23859856.8
Баянхонгор	25221.3	31291.0	53078.4	54674.3
Улсын дүнд аймгийн эзлэх хувь	0,19	0.20	0.25	0,23

Улсын худалдааны нийт борлуулалтын 1.7 хувийг Баруун бүсийн, 2,2 хувийг Хангайн бүсийн, 4,8 хувийг төвийн бүсийн, 1,6 хувийг зүүн бүсийн, 89,7 Улаанбаатарын борлуулалт эзэлж байна.

### ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, улс, бүсээр, сая төгрөгөөр

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	Улсын дүнд бүсийн эзлэх хувийн жин	
					2018.IV	2019.IV
Нийт борлуулалт /улсын дүнгээр/	13170891.3	15697003.3	20958538.4	23859856.8	100	100
Үүнээс: Баруун бүс	250615.0	255187.2	382626.6	405533.4	1,8	1,7
Хангайн бүс	297893.1	352636.8	504816.1	529899.9	2,4	2,2
Төвийн бүс	504208.6	624403.7	1151091.5	1144504.7	5,5	4,8
Зүүн бүс	179738.6	186590.5	375972.7	386781.1	1,8	1,6
Улаанбаатар	11938436.0	14278185.1	18544031.5	21393137.7	88,5	89,7

Хангайн бүсийн Худалдааны нийт борлуулалтын 13.8 хувийг Архангай аймгийн, 10.3 хувийг Баянхонгор аймгийн, 7.1 хувийг Булган аймгийн, 27.7 хувийг Өвөрхангай аймгийн, 22.8 хувийг Хөвсгөл аймгийн, 18,3 хувийг Орхон аймгийн борлуулалт эзэлж байна.

### ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ, хангайн бүсийн аймгаар, сая төгрөгөөр

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	Бүсийн дүнд хангайн бүсийн аймгийн эзлэх хувийн жин	
					2018.IV	2019.IV
Нийт борлуулалт /хангайн бүсийн дүнгээр	297893.1	352636.8	504816.1	529899.9	100	100
Үүнээс: Архангай	36634.8	43267.5	65613.3	72922.3	13,0	13,8
Баянхонгор	25221.3	31291.0	53078.4	54674.3	10,5	10,3
Булган	9817.5	13316.2	19132.6	37436.7	3,8	7,1
Өвөрхангай	85562.3	85108.7	127888.6	147070.7	25,3	27,7
Хөвсгөл	46408.5	96392.6	109667.4	120727.1	21,7	22,8
Орхон	94248.7	83260.8	129435.8	97068.7	25,6	18,3

ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН САЛБАР-2019

Баянхонгор хот  
2020 он

## **Салбарын онцлог**

Зочид буудлын үйлдвэрлэлт нь аялал жуулчлал, нийтийн хоолны үйлчилгээ гэх мэт бусад үйлчилгээний салбаруудтай уялдаатай, тэр дундаа хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаатай салшгүй холбоотой онцлог салбар юм.

Зочид буудлууд үндсэн үйл ажиллагаанаас гадна ресторан, бар зэргийг ажиллуулдаг. ҮСХ нь зочид буудлын мэдээллийг “Монголын зочид буудлын холбоо”-ноос гаргасан зэрэглэлийн дагуу, нийтийн хоолны салбарыг ресторан, кафе, цайны газар, гуанз, катеринг гэсэн төрлүүдээр нэгтгэн гаргаж байна.

### **Хамрах хүрээ**

Салбарын нэр: ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦААР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ салбарт зочид, аялагчдыг богино хугацаанд байраар хангах үйл ажиллагааг хамруулна. Мөн оюутан, ажиллагч болон бусад хүмүүсийг урт хугацаагаар байр сууцаар хангах үйл ажиллагааг оруулна.

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын I дүгээр салбарын 55 дахь дэд салбар болох үйлчилгээнд хамаарах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүгдийг оруулна.

Үүнд:  5510 - Богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагаа;  
 5520 - Автомашины зогсоол бүхий зуслан, чөлөөт цагаа өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа;  
 5590 - Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа.

Салбарын нэр: НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ салбарт нийтийн хоолны газраар хийгдэх шууд хэрэглэх зориулалттай хоол хүнс, ундаагаар үйлчилдэг, байнгын эсвэл түр ажиллагаатай уламжлалт ресторан, зоогийн газар, цайны газар, өөртөө үйлчлэх эсвэл хоолоо авч явах зориулалттай хоолны газрын үйл ажиллагааг хамруулна.

“Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ын I дүгээр салбарын 56 дугаар дэд салбарын дараах үйл ажиллагааг оруулна.

Үүнд:  5610 - Ресторан, хүнсний явуулын үйлчилгээ;  
 5621 - Тусгай захиалгат хоолоор үйлчлэх үйлчилгээ;  5629 - Хоол хүнсээр үйлчлэх бусад үйл ажиллагаа;  
 5630 - Ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа.

## ААНБ-ын тоо

Бизнес регистрийн санд бүртгэлтэй зочид буудал, зоогийн газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 24 ААНБ байгаа нь нийт аж ахуйн нэгж, байгууллагын 1,7 хувийг эзэлж байна.

Зочид буудал, зоогийн газрын салбарын  
үйл ажиллагаа явуулж байгаа ААН, Байгууллагын тоо

Үзүүлэлт	2018	2019
Аймгийн Нийт аж ахуйн нэгж, Байгууллагын тоо	1262	1394
Үүнээс: Зочид буудал, зоогийн газрын салбарын ААНБ-ын тоо	20	24
Зочид буудал, зоогийн газрын салбарын ААНБ-ын эзлэх хувь	1.6	1.7

2019 оны байдлаар Зочид буудал, зоогийн газарт 975 хүн ажиллаж байгаа бөгөөд аймгийн нийт ажиллагсдын 2,9 хувийг эзэлж байна.

## Зочид буудал, зоогийн газарт ажиллагчдын тоо

Үзүүлэлт	2016	2017	2018	2019
Аймгийн нийт ажиллагчдын тоо	40009	40921	41458	33384
Зочид буудал, зоогийн газрын салбарын ажиллагчдын тоо	601	863	996	975
Аймгийн нийт ажиллагчдад эзлэх хувь	1.5	2.1	2.4	2.9

2019 онд зочид буудал, зоогийн газрын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуйн нэгж байгууллагуудаас 21 ААНэгжийг түүврээр сонгон ҮСХорооноос ирүүлсний дагуу статистик мэдээнд улирал тутам хамруулсан.

Дээрх сонгогдон ирсэн Аж ахуйн нэгжийн нийт орлого 666,3 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оныхоос 11,7 хувиар өсчээ.

## ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2019/2018
Нийт орлого /сая төгрөг/	381,1	347,5	596,6	666,3	111.7



Аймгийн зочид буудал, зоогийн газрын нийт орлого улсын зочид буудал, зоогийн газрын нийт орлогын 0,08 хувийг эзэлж байна.

### ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО улс, аймгийн дүнгээр,сая төгрөгөөр

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV
Нийт орлого /улсын дүнгээр/	392374.9	479389,8	633254,0	766590.9
Баянхонгор	381.1	347.5	596,6	666.3
Улсын дүнд аймгийн эзлэх хувь	0,10	0.07	0.09	0,08

Улсын Зочид буудал, зоогийн газрын нийт орлогын 0.9 хувийг Баруун бүсийн, 4,2 хувийг Хангайн бүсийн, 4,9 хувийг төвийн бүсийн, 1,7 хувийг зүүн бүсийн, 88,3 Улаанбаатарын нийт орлого эзэлж байна.

**ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО, улс, бүсээр, сая төгрөгөөр**

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	Улсын бүсийн хувийн жин дүнд эзлэх	
					2018.IV	2019.IV
Нийт орлого /улсын дүнгээр/	392374.9	479389.8	633254.0	766590.9	100	100
Үүнээс:Баруун бүс	3352.1	3871.3	4536.0	7350.3	0,7	0,9
Хангайн бүс	18822.0	22077.6	26605.3	32262.4	4,2	4,2
Төвийн бүс	16712.2	18879.0	27199.9	37658.9	4,3	4,9
Зүүн бүс	4029.6	4748.2	8055.4	12932.4	1,3	1,7
Улаанбаатар	349459.0	429813.6	566795.3	676386.9	89,5	88,3

Хангайн бүсийн Зочид буудал, зоогийн газрын нийт орлогын 6.2 хувийг Архангай аймгийн, 2.1 хувийг Баянхонгор аймгийн, 4.3 хувийг Булган аймгийн, 7.6 хувийг Өвөрхангай аймгийн, 16.0 хувийг Хөвсгөл аймгийн, 63,8 хувийг Орхон аймгийн орлого эзэлж байна.

**ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО,хангайн бүсийн аймгаар, сая төгрөгөөр**

/Сонгогдсон ААН-ийн дүнгээр/

Үзүүлэлт	2016-IV	2017-IV	2018-IV	2019-IV	Хангайн бүсийн хувийн жин дүнд эзлэх	
					2018.IV	2019.IV
Нийт орлого /хангайн бүсийн дүнгээр/	18822.0	22077.6	26605.3	32262.4	100	100
Үүнээс:Архангай	1049.4	1420.1	1692.0	1995.7	6,3	6,2
Баянхонгор	381.1	347.5	596.6	666.3	2,2	2,1
Булган	654.1	762.9	902.0	1393.2	3,4	4,3
Өвөрхангай	1719.3	2223.6	1388.5	2461.5	5,2	7,6
Хөвсгөл	1475.7	1823.5	2388.0	5176.6	9,1	16,0
Орхон	13542.5	15500.1	19638.0	20569.2	73,8	63,8

## ДҮГНЭЛТ

Аймгийн хэмжээнд худалдааны салбарт 2019 онд 3.7 мянган хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагчдын 11.1 хувьтай тэнцэж байна. Энэ салбарт ажиллагчдын жилийн өсөлтийг нийт ажиллагчдын жилийн өсөлттэй харьцуулан үзвэл 2018 онд 13.9 хувиар, 2019 онд 38,0 хувиар өссөн байна. Энэ нь аймгийн худалдааны салбарын ажиллах хүчний хэмжээ нэмэгдэж байгааг илтгэхийн зэрэгцээ тус салбар нь аймгийн нийгэм, эдийн засагт чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

2019 онд зочид буудал, зоогийн газрын салбарт 0.9 мянган хүн ажиллаж байгаа нь аймгийн нийт ажиллах хүчний 2.9 хувийг бүрдүүлж байна.

Аймгийн Худалдааны салбарын нийт борлуулалт 2019 онд 54674.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 1595.9 сая төгрөг буюу 3.0 хувиар, Зочид буудал, зоогийн газрын салбарын нийт орлого 666.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 69.7 сая төгрөг буюу 11.7 хувиар тус тус өссөн байна. Аймгийн Худалдааны салбарын нийт борлуулалт 2019 онд улсын худалдааны салбарын нийт борлуулалтын 0,2 хувийг, хангайн бүсийн аймгуудын худалдааны салбарын нийт борлуулалтын 10,3 хувийг бүрдүүлж байна. Аймгийн зочид буудал, зоогийн газрын салбарын нийт орлого 2019 онд улсын зочид буудал, зоогийн газрын салбарын нийт орлогын 0,08 хувийг, хангайн бүсийн аймгуудын зочид буудал зоогийн газрын салбарын нийт орлогын 2,1 хувийг бүрдүүлж байна.

Аймгийн Худалдааны үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 2019 онд аймгийн ДНБ-ий 30.2 хувийг бүрдүүлж байна.

Аймгийн Худалдааны салбарын хөдөлмөрийн бүтээмж 2019 онд 14.7 сая төгрөг болж, өмнөх оноос 3.4 сая төгрөгөөр, Зочид буудал, зоогийн газрын салбарынх 0.7 сая төгрөг болж, өмнөх оноос 84,3 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Эдгээрээс дүгнэхэд аймгийн худалдааны салбар нь аймгийн эдийн засагт чухал байр суурийг эзэлж байгаа бол зочид буудал, зоогийн газрын салбарын орлого нь хэдийгээр нэмэгдэж байгаа ч нийт нэмэгдэл өртөг, хөдөлмөрийн бүтээмж нь бусад салбаруудтай харьцуулахад доогуур байна.

**Судалгааны хамрах хугацаа: 2015-2019 оны гүйцэтгэл**

***Ашигласан материал:***

Жилийн эцсийн мэдээ тайлан

Монгол улсын статистикийн эмхэтгэл

Статистикийн шинжилгээ судалгаа хийх гарын авлага ҮСХ 2007 он

Улсын ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл-2019 он

Ажиллах хүчний судалгааны үр дүн

[www.nso.mn](http://www.nso.mn)

[www.1212.mn](http://www.1212.mn)